# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН 2025 ОН

| Д/д | Шийдвэрийн нэр, огноо | Зүйл заалтын дугаар | Зүйл, заалтын агуулга | Хэрэгжилтийн тайлан | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжээгүй шалтгаан | Хяналтаас хасах үндэслэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **1.Монгол улсын хууль (зөвхөн өөрт хамааралтай заалт)** | | | | | | | |
| 1 | Биеийн тамир, спортын тухай хууль 2024.06.05 | 8 бүлэг 41 зүйл | Биеийн тамир, спортын тухай /Шинэчилсэн найруулга/ | Биеийн тамир, спортын тухай хуулийг орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Биеийн тамир, спортын газар, Усан спорт сургалтын төв, спортын 9 /Алтанбулаг, Баянгол, Баруунбүрэн, Ерөө, Сайхан, Мандал, Цагааннуур, Хүдэр, Дулаанхаан/ цогцолбор, спортын холбоод мөрдлөг болгон ажиллаж байна. Биеийн тамир, спортын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 9 дүгээр зүйл, Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 183 дугаар тогтоолын хэрэгжилтээр 2025 онд Монголын Бүх ард түмний спортын 17 дугаар наадамд, Хүүхдийн Спортын өвөл, зуны VIII наадамтай жилд аймагтаа спортын 16 төрлөөр анхан шатны тэмцээнийг зохион байгуулсан. Биеийн тамир спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг биеийн тамир спортын салбарын ажилчдын зөвлөгөөн, сургалтаас гарсан шийдвэр, санал асуулгын дагуу бэлтгэн найруулж их хуралд өргөн барьснаар 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Монгол Улсын Их Хурал батлан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нийт спортын заал 54, гадаа талбай, цэнгэлдэх, төрөлжсөн талбай 56, спортын зэрэг цолтой 450 тамирчин тоологдож жил бүр нэмэгдүүлэн Сайхан сумын Номгон тосгон, Орхон суманд улсын төсвийн 4,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, Түшиг суманд хувийн хэвшлийн компани нийгмийн хариуцлагын хүрээнд спорт цогцолборуудыг барьж ашиглалтад оруулахаар ажиллаж байна. | 100 | - | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 20 дугаар зүйлийн 20.8.10 заасны дагуу спортын I-III зэргийг спортын холбоодод шилжүүлэн харин өндөр зэрэгтэй цолыг /ОУХМ, СМ, СДМ/ Монгол улсын магадлан итгэмжлэгдсэн улсын холбоод олгож байхаар шийдвэрлэсэн. | | | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | | | |
| 2.**Улсын Их Хурлын тогтоол** | | | | | | | |
| 2 | Монгол Улсын Их Хурлын тогтоол 2024.07.10 | 13 | Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай | Ерөнхий сайдын 39 тоот захирамж, Улсын Их Хурлын 13 дугаар тогтоолоор Монгол улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир спортын Улсын хорооны харьяанд босоо удирдлагатай болж шилжин бүтцэд өөрчлөлт орсон. Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны ХЭГ/1760 дугаар, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын 01/2515 дугаар албан бичгээр байгууллагын бүтэц зохион байгуулалт, чиг үүргийг оновчтой болгох, давхардлыг арилгах, сул орон тоог нөхөх болон шинээр ажлын байр бий болгохгүй, өндөр настны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн албан хаагчийн орон тоог царцааж, томилгоо хийхгүй, батлагдсан цалинг орон тоонд багтаан төсвийн зардлыг хэмнэж, Усан спорт сургалтын төв болон 8 сум, 1 тосгоны спортын цогцолбортой нийт 64 орон тоотойгоор ажиллаж байна. | 100 | - | - |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | | | |
| 3.**Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | | | |
| 3 | Ерөнхийлөгчийн зарлиг 2010.03.26 | 53 | Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 53 тоот зарлигийг хэрэгжүүлэх хүрээнд Бие бялдрын түвшин тогтоох сорилыг 4 болон 10 дугаар сард сорилын төв болон 9 сумын спорт цогцолборт зохион байгуулсан. Сорилын төвд 21 байгууллагын эрэгтэй 406, эмэгтэй 427 нийт 833 иргэнээс, Алтанбулаг, Баруунбүрэн, Баянгол, Ерөө, Мандал, Сайхан, Цагааннуур, Дулаанхаан, Хүдэр сумын спорт цогцолборын арга зүйчид | 100 | - | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | уламжлалт аргаар 11499 иргэнээс, нийт 12,332 иргэнээс бие, бялдрын түвшин тогтоох сорил авч сорилын дүн, мэдээг программд шивж оруулсан. Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдагчдаас эхний хагас жил А үнэлгээ 1608, В үнэлгээ 1700, С үнэлгээ 1381 байсан бол сүүлийн хагас жилд А-2520, В-3123, С-2808 болж нэмэгдсэн. Сорилд хамрагдсан 11,499 иргэний 73,4 хувь нь АВС үнэлгээтэй байна. Өдөр тутмын сорил авч буй үйл явцын мэдээллийг байгууллагын фэйсбүүкт оруулж, Сорилын төвийн үйл ажиллагаа, сорил хэрхэн авч байгаа талаар аймгийн иргэдэд сурталчилж ажилласан. “Бие бялдрын түвшин тогтоох сорилын төв”-д эрэгтэй 406, эмэгтэй 427 нийт 833 иргэнээс сорил авч нас, биеийн онцлогт тохирсон дасгал, хөдөлгөөнийг төхөөрөмжтэй хослуулан хийх зааварчилгаа өгсөн. Сорилд хамрагдсан иргэдийн сорилын дүнг тайлбарлан, хоол зүйн зөвлөгөө, өөрийн биеийн онцлогт тохирсон дасгал хийх зөвлөмжийг өгч “Бие бялдрын түвшин тогтоох сорилын төв”-ийн дэргэдэх чийрэгжүүлэх төв, фитнес, спиннинг, усан спорт сургалтын төвөөр нийт давхардсан тоогоор 4840 иргэн үйлчлүүлсэн. | | | |
| | | | | | | | Хэсгийн дундаж: 100 хувь |
| | | | **Засгийн газрын тогтоол** | | | | |
| 4 | Засгийн газрын тогтоол 2009.01.07 | 5 | Нийтийн биеийн тамир спортын талаар авах зарим арга хэмжээний тухай | Биеийн тамир, спортын үйл ажиллагааг зохицуулах журмад нэмэлт өөрчлөлт оруулан Монгол улсын засгийн газрын 05 тоот тогтоолоор “Өөртөө Цаг гаргая” уриан дор бүх нийтийг хамарсан Биеийн тамир, спортын 237 төрлийн арга хэмжээг төрийн бус байгууллага, спорт холбоодтой хамтран сар бүр зохион байгуулж насны бүлгээр давхардсан тоогоор нийт 102,892 иргэн, Улсын аварга шалгаруулах гурван удаагийн тэмцээнд 1584 тамирчин оролцуулан 28 алт, 57 мөнгө, 49 хүрэл медалийг хүртсэн амжилтыг үзүүлсэн. Монголын хүүхдийн спортын Зуны VIII наадмын шигшээ тэмцээнд 237 тамирчинг спортын 23 | 90 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төрлөөр оролцуулан 8 алт 5 мөнгө 14 хүрэл медаль, Хөгжлийн бэрхшээлтэй 3 төрлийн тэмцээнд 10 тамирчинг оролцуулан 1 алт, 2 мөнгөн хүртсэн амжилтыг үзүүлсэн. Нийт 35 алт 66 мөнгө 63 хүрэл бүгд 164 медаль хүртэж медалийн чанарыг 20,7 хувиар өсгөсөн. Аймгийн шигшээ багийн тамирчдаас Олон Улсын 4 тэмцээнээс /Бокс, чөлөөт бөх/ 1 мөнгө, 1 хүрэл Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 2 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. Аймгийн Засаг даргын тамгын газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоотой хамтран “Бид хамтдаа” спортын 5 төрөлт тэмцээнийг 05 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Хүдэр сумын спорт цогцолборт зохион байгуулж нийт 15 сум, 2 тосгоны 170 иргэн хамрагдсан. | | | |
| 5 | Засгийн газрын тогтоол 2018.06.13 | 173 | Журам шинэчлэн батлах тухай | Аймгийн болон сумдын Засаг дарга нар дэмжин үйл ажиллагааг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж тэмцээнд амжилт гаргасан 117 хүнийг шагнаж урамшуулсан. Монголын Хүүхдийн спортын наадамд оролцож медаль хүртсэн 56 тамирчинг 58.5 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. | 100 | - | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Засгийн газрын тогтоол 2018.06.20 | 183 | Журам шинэчлэн батлах тухай | Улсын аварга шалгаруулах 3-н удаагийн тэмцээнд 1584 тамирчин оролцуулан 28 алт, 57 мөнгө, 49 хүрэл медалийг хүртсэн амжилтыг үзүүлсэн. Монголын хүүхдийн спортын Зуны VIII наадмын шигшээ тэмцээнд 237 тамирчинг спортын 23 төрлөөр оролцуулан 8 алт 5 мөнгө 14 хүрэл медаль, Хөгжлийн бэршээлтэй 3 төрлийн тэмцээнд 10 тамирчинг оролцуулан 1 алт, 2 мөнгөн хүртсэн амжилтыг үзүүлсэн. Нийт 35 алт 66 мөнгө 63 хүрэл бүгд 164 медаль хүртэж медалийн чанарыг 20,7 хувиар өсгөсөн. Аймгийн шигшээ багийн тамирчдаас Олон Улсын 4 тэмцээнээс /Бокс, чөлөөт бөх/ 1 мөнгө, 1 хүрэл Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 2 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. | 100 | - | - |
| 7 | Засгийн газрын тогтоол 2005.09.14 | 189 | Үндэсний шигшээ баг байгуулах тухай | 2025 онд шигшээ багийг спортын 4 төрлөөр (Бадминтон, Буудлага, Хөнгөн атлетик, Усан сэлэлт) нэмэгдүүлж 77 тамирчин 4 багштай хичээллэж байна. Аймаг орон нутгийн онцлог, боловсон хүчний хангамж спортын материаллаг баазад түшиглэн волейбол, бокс, чөлөөт бөх, жүдо, шатар, таеквондогийн төрлүүдийг түлхүү хөгжүүлэн алдар цуутай тамирчдыг төрүүлэн гаргахаар хэсэгчилсэн болон Улсын шигшээ багтай хамтарсан бэлтгэлүүдийг хийлгэн ажиллаж байна. Улсын шигшээ багийн бүрэлдэхүүнд Сэлэнгэ аймгаас волейбол, бокс, жүдо, буудлага, таеквондогийн төрлүүдээр 9 тамирчин хичээллэж 2028 оны олимпод оролцох эрхийн төлөө өрсөлдөх боломжийг бүрдүүлж байна. | 100 | - | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Засгийн газрын тогтоол 2019.01.23 | 33 | Дүрэм батлах тухай | Байгууллагын даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Ёс зүйн дэд хороо байгуулах тухай” А/14 тушаалаар ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулж, Биеийн тамир, спортын газрын Хөдөлмөрийн дотоод журам, Усан спорт сургалтын төвийн үйлчилгээний стандарт, ёс зүйн талаар нэмэлт өөрчлөлтүүдийг оруулан багш, ажилчид, хичээллэгч, үйлчлэгчдийн мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллах нөхцөл стандартыг баримтлан ажиллаж байна. | 100 | - | - |
| 9 | Засгийн газрын тогтоол 2024.12.25 | 238 | Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай | Улсын Их Хурлын тогтоолоор Монгол улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир спортын Улсын хорооны харьяанд босоо удирдлагатай болж шилжин бүтцэнд өөрчлөлт орсон. Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны ХЭГ/1760 дугаар, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын 01/2515 дугаар албан бичгээр байгууллагын бүтэц зохион байгуулалт, чиг үүргийг оновчтой болгох, давхардлыг арилгах, сул орон тоог нөхөх болон шинээр ажлын байр бий болгохгүй, өндөр настны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн албан хаагчийн орон тоог царцааж, томилгоо хийхгүй, батлагдсан цалинг орон тоонд багтаан төсвийн зардлыг хэмнэж, Усан спорт сургалтын төв болон 8 сум, 1 тосгоны спортын цогцолбортой нийт 64 орон тоотойгоор ажиллаж байгаа бөгөөд ТЗ, ТҮМ, ТҮСБ, ТҮБД, ТҮ шаталбаруудаар цалинжуулж байна. | 100 | - | - |
| Хэсгийн дундаж:98,3 хувь | | | | | | | |
| **Ерөнхий сайдын захирамж** | | | | | | | |
| 10 | Ерөнхий сайдын захирамж 2020.08.28 | 39 | Биеийн тамир, спортын | Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын Улсын хороонд босоо удирдлагаар харьяалагдан аймаг, орон нутагт биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа | 100 | - | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | улсын хорооны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай | спортын 22 холбоо, 9 клуб, сумдын 9 спортын цогцолбортой үйл ажиллагаа явуулан ажиллаж байна. | | | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | | | |
| **Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | | | |
| 11 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 2025.01.29 | 6 | | Засгийн газрын 6 дугаар хуралдааны тэмдэглэл “Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр”-т тусгагдсан 4 бодлогын 16 чиглэлийн 620 зорилтыг хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч ажиллах тухай 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн тэмдэглэлийг танилцуулан байгууллагын албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан. | 90 | - | - |
| Хэсгийн дундаж: 90 хувь | | | | | | | |
| **Ерөнхий сайдын албан даалгавар** | | | | | | | |
| 12 | Ерөнхий сайдын албан даалгавар 2025.06.18 | 01 | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай | Монгол улсын Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг мөрдөж, төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг өндөржүүлэн, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор Байгууллагын даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Ёс зүйн дэд хороо байгуулах тухай” А/14 тушаалаар ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулж, Биеийн тамир, спортын газрын Хөдөлмөрийн дотоод журам, Усан спорт сургалтын төвийн үйлчилгээний стандарт, ёс зүйн талаар нэмэлт өөрчлөлтүүдийг оруулан багш, ажилчид, хичээллэгч, үйлчлүүлэгчдийн мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллах нөхцөл стандартыг | 100 | - | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | баримтлан ажиллаж байна. Мөн байгууллагын нийт албан хаагчдад Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газрын хуулийн хэлтэс, Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил хамгааллын газар, “Нарны алтан оньс” Төрийн бус байгууллагуудтай хамтран Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн талаар сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж ажиллалаа. | | | |
| 13 | Ерөнхий сайдын албан даалгавар 2025.03.06 | 02 | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай | Монголын Хүүхдийн спортын өвөл, зуны VIII наадмын анхан шатны 21 спортын төрлийн 693 өсвөрийн тамирчин, шигшээ тэмцээнд 237, Монголын Бүх ард түмний спортын 17-р наадмын шигшээ тэмцээнд спортын 6 төрөлд 64 тамирчин, Иргэдийн спортын их наадмын анхан, дунд шатанд 1279, шигшээ тэмцээнд 127, “Сэлэнгэ марафон” бүх нийтийн гүйлтэд 1950 иргэн, нийт 4350 иргэнийг panel.sport.gov.mn, regional.gov.mn сайтад бүртгэсэн. 2025 онд олон улсын хэмжээний мастер, спортын мастер авсан тамирчид emongolia системд бүртгэгдсэн. 2025 онд Биеийн тамир, спортын газарт нийт 1,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. 2006 оны 269 тоот захирамжийн дагуу 2025 онд шигшээ багийг спортын 4 төрлөөр (Бадминтон, Буудлага, Хөнгөн атлетик, Усан сэлэлт) нэмэгдүүлж 77 тамирчин 4 багштай хичээллэж байна. | 100 | - | - |
| 14 | Ерөнхий сайдын албан даалгавар 2025.07.08 | 03 | Төрийн албаны сахилга дэг журам, хариуцлагыг | Монгол улсын Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг мөрдөж, төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг өндөржүүлэн, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор Байгууллагын даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Ёс зүйн дэд хороо байгуулах тухай” А/14 тушаалаар ёс | 100 | - | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | чангатгах тухай | зүйн дэд хороог шинэчлэн байгуулж, Биеийн тамир, спортын газрын Хөдөлмөрийн дотоод журам, Усан спорт сургалтын төвийн үйлчилгээний стандарт, ёс зүйн талаар нэмэлт өөрчлөлтүүдийг оруулан багш, ажилчид, хичээллэгч, үйлчлэгчдийн мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллах нөхцөл стандартыг баримтлан ажиллаж байна. Мөн байгууллагын нийт албан хаагчдад Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газрын хуулийн хэлтэс, Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил хамгааллын газар, “Нарны алтан оньс” Төрийн бус байгууллагуудтай хамтран Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн талаар сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж ажилллалаа. | | | |
| Хэсгийн дундаж:100 хувь | | | | | | | |
| Нийт дундаж: 98,5 хувь | | | | | | | |

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА У.БАТМӨНХ

ХЭРЭГЖИЛТ ТАЙЛАГНАСАН:
ТОГТООЛ, ШИЙПВЭР, ТАЙЛАН МЭДЭЭ, ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ОРХОНЧИМЭГ

## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (2025 он)

| Д/д | Үйл ажиллагаа | № | Шалгуур үзүүлэлт | Зорилтот | Хүрсэн | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх | | | | | | |
| 1. | Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан (**дотоод сургалт)** | 1.1 | Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо: | 11 | 86 | Зорилтот түвшин хэсэгт байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусгасан дүнг бичнэ. 1.Зөвхөн сертификаттай сургалт болон 4-өөс дээш цагийн сургалтыг тайлагнана. (холбогдох материалыг хавсаргах) |
| | | Үүнээс | Ажлын байран дахь сургалт | 11 | 11 | |
| | | | Мэргэшүүлэх сургалт | 0 | 5 | |
| | | | Туршлага солилцох арга хэмжээ | 0 | 3 | |
| | | | Бусад | 0 | 5 | |
| | | 1.2 | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | 64 | 2794 | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 28 | 1730 | |
| | | | Эрэгтэй албан хаагч | 29 | 1064 | |
| | | | Удирдах албан тушаалтан | 3 | 3 | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 40 | 1525 | |
| | | 1.3 | Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь | - | 100% | |
| 2. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан **(гадаад сургалт)** | 2.1 | Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо | - | - | 2.Гадаад улс орон, хилийн чанадад хамрагдсан сургалтыг тайлагнана. (холбогдох материалыг хавсаргах) |
| | | 2.2 | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | - | - | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | - | - | |
| | | | Эрэгтэй албан хаагч | - | | |
| | | | Удирдах албан тушаалтан | - | - | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | - | - | |
| | | 2.3 | Гадаад сургалтад хамруулсан байдал: | 10-аас дээш | - | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал | 3.1 | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | Тайлант оны гүйцэтгэлээр | |
| 4 | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн | 4.1 | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь (15%-аас доош байх) | $\frac{\text{чөлөөлөгдсөн албан хаагч}}{\text{албан хаагчдын дундаж}} * 100\%$ | |
| | | 4.2 | Шатлан дэвшүүлсэн албан хаагчийн тоо | 1 | - |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | - | - |
| | | | Эрэгтэй албан хаагч | 1 | - |
| | | | Удирдах албан тушаалтан | - | - |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 1 | - |
| | | 4.3 | Шилжүүлсэн болон сэлгэн ажиллуулсан албан хаагчийн тоо | - | - |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | - | - |
| | | | Эрэгтэй албан хаагч | - | - |
| | | | Удирдах албан тушаалтан | - | - |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | - | - |
| Нийгмийн баталгааг хангах хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ | | | | | |
| 5. | Албан хаагчид олгосон цалин урамшуулал, нөхөх төлбөр, тусламж, дэмжлэг | | | - | Тайлант оны гүйцэтгэлээр |
| | **5.1.Улирлын урамшуулал олгосон байдал** | Нийт албан хаагчийн тоо | | 1-р улиралд 44 албан хаагч, 2-р улиралд 62 албан хаагчид нийт | - |
| | | Урамшуулал олгосон албан хаагчийн тоо | | 106 | - |
| | | Үүнээс | удирдах | 3 | - |
| | | | гүйцэтгэх | 61 | - |
| | | Нийт олгосон урамшууллын хэмжээ | | 20-40 | - |
| | | Үүнээс | I улирал | 20,406,000 | - |
| | | | II улирал | 29,951,200 | - |
| | | | III улирал | - | - |
| | | | IV улирал | - | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Цалингийн нийт санд эзлэх хувь | 27,5 | - |
| | **5.2.Нөхөх төлбөрт олгосон зардал, нийт:** | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | 5.2.1.албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2) | албан хаагчийн тоо | 6 | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | 1,342,000 | |
| | 5.2.2.албан ажлын хэрэгцээнд хувийн автомашин хэрэглэсний нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 3.2) | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | |
| | 5.2.3.төрийн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 5.1, 5.2) | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | 5.2.4.хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг, гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд эмчилгээний зардлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 7.1) | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | 5.2.5.гадаад улс болон орон нутагт ажиллахаар томилогдсон төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 4.1) | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | 5.2.6.замын зардлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 6.1) | албан хаагчийн тоо | -- | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | **5.3.бусад нөхөх төлбөрт олгосон зардал, нийт:** | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | 5.3.1.төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардал болон ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон нийтийн тээврийн унааны зардлын хэмжээ | албан хаагчийн тоо | 68 | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | 160,350,000,000 | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | (“Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.2, 8.4) | | | |
| | 5.3.2.ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно. (“Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.3) | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | 5.3.3.төрийн албанаас түр чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчид тухайн албан хаагчийн албан тушаалын 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нөхөх төлбөр (“Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.5) | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | 5.3.4.Төрийн албан хаагчийг эрхэлсэн ажил, эзэмшсэн мэргэжлийн дагуу 180 хүртэл хоногийн хугацаагаар эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу төрийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэхэд түүний эрхэлж байгаа албан тушаалын цалинг олгоно. (“Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.6) | албан хаагчийн тоо | | |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | |
| | **5.4.Төрийн албан хаагчид олгосон тусламж, нийт:** | албан хаагчийн тоо | 3 | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | 102,597,852 | - |
| | 5.4.1.өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн албан хаагчид олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж | албан хаагчийн тоо | 3 | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | 102,597,852 | - |
| | 5.4.2.албан үүргээ гүйцэтгэх явцад амь нас хохирсон албан хаагчийн ар гэрт олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | **5.5.төрийн албан хаагчийн нийтлэг баталгаанд зарцуулсан зардал, нийт:** | албан хаагчийн тоо | - | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | | албан хаагчийн тоо | - | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 5.5.1.ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид 1.5 сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - |
| | 5.5.2.орон байраар хангагдахад төрөөс үзүүлсэн дэмжлэг | албан хаагчийн тоо | - | Аймгийн төсвийн 767,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Биеийн тамир спортын газрын барилгын гадна фасадны барилга угсралтын ажлыг “Преспектив шийдэл” ХХК 2025 оны 05 дугаар сараас эхлэн барилгын ажил 90 хувийн гүйцэтгэлттэй явагдаж байна. Сэлэнгэ аймгийн газрын албатай хамтран 14 ажилтанд Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Тужийн нарсан дунд 07 га газрыг өмчлүүлэх ажлыг зохион байгуулсан. |
| | | зарцуулсан хөрөнгийн хэмжээ | - | |
| | 5.5.3.албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг сайжруулахад зарцуулсан зардал | зарцуулсан хөрөнгийн хэмжээ | - | Аймгийн төсвийн 767,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Биеийн тамир спортын газрын барилгын гадна фасадны барилга угсралтын ажлыг “Преспектив шийдэл” ХХК 2025 оны 05 дугаар сараас эхлэн барилгын ажил 90 хувийн гүйцэтгэлттэй явагдаж байна. Усан спортын төвд иргэдэд үзүүлэх үйлчилгээ, чанар хүртээмжийг сайжруулахаар 1 тонны халаалтын 2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | ширхэг халаагуурыг 13,2 сая төгрөгөөр авч шинээр суурилуулсан. Усан спортын төвд иргэдэд үзүүлэх үйлчилгээ, чанар хүртээмжийг сайжруулахаар 1 тонны халаалтын 2 ширхэг халаагуурыг 13,2 сая төгрөгөөр авч шинээр суурилуулсан. Албан хаагчдын хүүхдүүдийн аюулгүй байдал хамт олны ая тухтай ажиллах нөхцөл бололцоог хангах зорилгоор байгууллагын дотоод нөөцөөс Хүүхэд хамгааллын (Хүүхдийн өрөө)-г 5.0 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийж тохижуулан шинээр байгуулсан. Биеийн тамир спортын газрын сургалтын танхимыг багш ажилчид засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн. Сургалтын өрөөнд 271000төг 6 ширээ шинээр засварлах, өлгүүр ширээний булан 75000 төгрөг, будаг, эмульс цахилгааны утас, зэрэг бараа материалд 623000 төгрөг нийт 669000 төгрөгийн барилгын материал зарцуулан бэлэн болгосон. Алтанбулаг, Ерөө сумдын Байгаль |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | орчны газартай хамтран Түлшний мод бэлтгэх 6ш зөвшөөрөл, УБТЗ-ын Сүхбаатар зангилаатай хамтран 6 айлын 6 тонн нүүрсийг шийдвэрлэсэн. Бадминтоны өрөөний засвар Байгууллагын 5.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар иргэн Э. Батцэцэгтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан Вакум хаалт, хана хийлгэсэн бөгөөд цахилгааны иж бүрэн засвар үйлчилгээ хийхэд 222500 төгрөг нийт 5.225.000 төгрөг зарцуулан бадминтоны өрөө тасалгааг тохижуулан сургалт дасгалжуулалт хийхэд бэлэн болгосон. Соёл, спорт аялал жуулчлал залуучуудын яамнаас хөрөнгө оруулалтаар ирсэн техник тоног төхөөрөмж тавилга эд хогшил Оффис сандал нэг бүрийн үнэ 290,000 төгрөг 10 ширхэг нийт үнэ 2.900.000 төгрөг, Оффис ширээ нэг бүрийн үнэ 675000 төгрөг, 10 ширхэг нийт үнэ 6.750.000 төгрөг, Уншигчдын ширээ нэг бүрийн үнэ 140,000 төгрөг 10 ширхэг нийт үнэ 1.400.000 төгрөг, 10 ширхэг, уншигчдын сандал, нэг бүрийн үнэ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | 70,000 төгрөг 10 ширхэг нийт үнэ 1.400.000 төгрөг 20 ширхэг бүгд үнэ 12,450,000 төгрөг, суурин компьютер нэг бүрийн үнэ 3.120.000 төгрөг, 10 ширхэг нийт үнэ 31.200.000 төгрөг бүгд 43,650,000 тус тус ирсэн. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос олсон нэмэлт орлогоос худалдан авсан усан спорт сургалтын төвд 2 ширхэг 13.200.000 төгрөгийн өртөгтэй ус халаах төхөөрөмж, сорил судалгааны төвд 4.400.000 төгрөгийн өртөгтэй Гүйлтийн зам, Спининг дугуй 3.520.000 төгрөгийн өртөгтэй 4 ширхэг, компьютерийн дэлгэц 660.000 төгрөгийн өртөгтэй,скайнер EPSON DS-77011 маркийн 1.235.000 төгрөгийн өртөгтэй эдгээр техник тоног төхөөрөмж тавилга эд хогшилыг байгууллагын өмчид бүртгэж эдэлгээний хугацааг тогтоосон. Хүдэр сумын спорт цогцолборын гадна талын төмөр сараалжин хашаа барих ажлыг орон нутгийн хөрөнгө оруулалтаар 7.350.000 төгрөгийг шийдвэрлүүлж, Улаанбаатар хотод төмөр хийцээр |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | хашаа барьдаг компаниудын үнийн судалгаа хийж, “Луут хан нүнжиг” ХХК-ыг сонгон 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр 564 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хашааг хийж гүйцэтгүүлсэн. Цагааннуур спорт цогцолбор Биеийн тамир спортын газрын хөрөнгө оруулалтаар Цагааннуур Спорт цогцолборт 2025 оны 10 дугаар сард 2.590.800 төгрөгийн заалны гадна хаалга, уурын зуухны хаалгыг сольж шинэчилсэн. Баянгол сумын 49”000”000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар Спорт цогцолборын гадна зогсоолыг хийж гүйцэтгэсэн. Сэлэнгэ аймгийн Засаг даргын 74,704,673 төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2025 оны 05 дугаар сард “Түрүү гарав” ХХК нь спорт цогцолборын Б заалны дээврийн засварын ажил хийж гүйцэтгэсэн. Сэлэнгэ аймгийн орон нутгийн 49,636,698 төгрөгийн санхүүжилтээр 2025 оны 01р сард “Түрүү гарав” ХХК нь спорт цогцолборын А, Б заалны агааржуулалт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | гэрэлтүүлгийн ажил хийсэн. Биеийн тамир спортын газрын 19,977,000 төгрөгийн санхүүжилтээр 2025 оны 10 дугаар сард “Шинэ шилдэг” ХХК байгууллагын эрэгтэй эмэгтэй ариун цэвэрийн өрөөний засварын ажлыг гүйцэтгэсэн. Мөн төв цэнгэлдэх хүрээлэнгийн зүлэг усалгаанд шаардагдах Бороожуулагч шланг 40 мм 2000метр, Гадна усалгааны шланг 25 мм 400м, Хомучик 20 ш, Хаалт 80мм*40мм 4 ш, тус тус 3.250.000 төгрөгийн хөрөнгө оруулалтыг аймгийн Засаг даргын тамгын газраас шийдвэрүүлсэн. |
| | 5.5.4.албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг (жилд) 1-ээс дээш | албан хаагчийн тоо | - | Сэлэнгэ аймгийн Салхит 3 дугаар багийн өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран алба хаагчдыг эрүүл мэндийн анхан шатны үзлэгт хамруулж цусан дахь сахрын хэмжээ, цусны ерөнхий шинжилгээ авч эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл хүргэсэн. |
| | | зарцуулсан хөрөнгийн хэмжээ | - | |

# ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2025.12.05 Сүхбаатар

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын их хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын албан даалгавар, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий Сайдын захирамж, албан даалгавар зэрэг Биеийн тамир спортын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтуудын биелэлт, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ өгч, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дүгнэлт, зөвлөмж гарган, мэдээллээр хангах, тайланг нэгтгэх,

## Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Засгийн газрын 2025 оны ”Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг удирдлага болгон, 2025 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэсэн хууль, тогтоол, шийдвэрийн биеийн тамир, спортын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтуудын хэрэгжилтийн гүйцэтгэлийн үр дүнг нотлох холбогдох материал судалгааг ашиглан,асуудал хариуцсан нэгжээс тайлбар, нэмэлт тодоруулга авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулж, бататган, хэрэгжилтийн тайлан, мэдээллийг үндэслэн удирдлага, зохион байгуулалтын болон талуудын хамтын ажиллагаа зэргийг харгалзан үнэлэв.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Биеийн тамир, спортын газрын 2025 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын тогтоол-1, Ерөнхийлөгчийн зарлиг-1, Засгийн газрын тогтоол-6, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-1, Ерөнхий сайдын албан даалгавар-3, зэрэг нийт 12 тогтоол, шийдвэрийг хяналтад авч журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийллээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад хяналтад авсан 12 тогтоол, шийдвэрийн 12 нь бүрэн хэрэгжсэн буюу 100 хувь биелэлттэйгээр дүгнэгдэж, биелэлтийн дундаж 98,5 хувьтай үнэлэгдэж байна.

Хяналтад авсан тогтоол, шийдвэрийг ангилан харуулбал:

| д/д | Эрх зүйн баримт бичиг | Шийдвэрийн заалт | Огноо дугаар | Өөрийн өгсөн үнэлгээ хувь |
|---|---|---|---|---|
| 1 | УИХ-ын тогтоол | “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” | 2024оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоол | 100 |
| 2 | Ерөнхийлөгчийн зарлиг | “Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай” | 2010 оны 03. дугаар сарын 26-ны өдрийн | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 53 дугаар зарлиг | |
| 3 | Засгийн газрын тогтоол | “Нийтийн биеийн тамир спортын талаар авах зарим арга хэмжээний тухай” | 2009 оны 01 дүгээр сарын 07 өдрийн 05 дугаар тогтоол | 90 |
| | | “Журам шинэчлэн батлах тухай” | 2018 оны 06 дугаар сарын 13 өдрийн 173 дугаар тогтоол | 100 |
| | | “Журам шинэчлэн батлах тухай” | 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 183 дугаар тогтоол | 100 |
| | | “Үндэсний шигшээ баг байгуулах тухай” | 2005 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 189 дүгээр тогтоол | 100 |
| | | “Дүрэм батлах тухай” | 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоол | 100 |
| | | “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” | 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоол | 100 |
| 4 | Ерөнхий сайдын захирамж | “Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай | 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 39 дүгээр захирамж | 100 |
| 5 | Ерөнхий сайдын албан даалгавар | “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” | 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01 тоот албан даалгавар | 100 |
| | | “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” | 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 02 дугаар албан даалгавар | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | Ерөнхий сайдын албан даалгавар | “Төрийн албаны сахилга дэг журам, хариуцлагыг чангатгах тухай” | 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 03 дугаар албан даалгавар | |
| 6 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр”-т тусгагдсан 4 бодлогын 16 чиглэлийн 620 зорилтыг хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч ажиллах тухай 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн тэмдэглэлийг | 2025 оны 01дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэл | 90 |

Дөрөв: Дүгнэлт, зөвлөмж

Биеийн тамир, спортын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтуудын хэрэгжилтэд байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, сайжируулж үр дүнг дээшлүүлэх,

Төрийн албан хаагчдын ажлын төлөвлөлт, тайлагналт зэрэгт холбогдох газраас сургалт авах, мэдлэг мэдээллээр хангах, баримт бичиг боловсруулах ур чадварыг дээшлүүлэх, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн судалгаа нотолгоо, баримтад тулгуурлан үнэн зөв тайлагнаж дадах, нэгжийн дарга нар бүх түвшинд ажлын гүйцэтгэлд хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч боловсронгуй болгоход тайлан хэрэгжилтийн талаар товч тодорхой заасан хугацаанд мэдээлэх, тайлагнах үүрэгтэй төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм журамд тусгах,

Тогтоол шийдвэрийн хэрэгжилт тогтмолжсон, бүрэн хэрэгжсэн, цаг үеийн шаардлагаар хэрэгжих боломжгүй болсон тогтоол, шийдвэрүүдийг дахин нягтлан хяналтаас хасч, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, захиргааны байгууллагуудын уялдаа холбоог сайжируулах, эргэн мэдээллэдэг байхыг зөвлөж байна.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Г. ЭНХТҮВШИН

ХЯНАСАН:
ДАРГА У. БАТМӨНХ